

2019 оны 12 дугаар сард импортлох стратегийн  
хүнсний сонгон шалгаруулалтын урилга

Шалгаруулалтын дугаар: СХИЗОСШ – 20191122

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлагдсан Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журмын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтыг үндэслэн 2019 оны 12 дугаар сард импортлох стратегийн хүнс / ҮХРИЙН МАХ / - ний нэр төрөл, тоо хэмжээнд багтаан зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлаж байна. Тоо хэмжээ – 497 тн

Оролцогч нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, битүүмжлэн, 2019 оны 12 дугаар сарын 04-ний 16 цагаас өмнө Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны 502 тоот өрөөнд бүртгүүлж хүлээлгэж өгнө. Үүнд:

1. Импортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг заасан албан бичиг;
2. Хуулийн этгээдийн нэр, байршил, хаяг, утас, цахим хаяг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, эрхэлж байгаа хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр;
3. Татварын өргүй болохыг нотолсон харьяалах татварын албаны тодорхойлолт (2019 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар);
4. Аудитаар баталгаажсан сүүлийн жилийн санхүүгийн тайлангийн хуулбар;
5. Хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдийн имтгэмжлэл олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр;
6. Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрийн байртай болохыг нотолсон мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт;
7. Импортлогч улсын үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;
8. Импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн байх;
9. Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд яамтай бодлогын гэрээ байгуулахад татгалзах зүйлгүй талаар мэдэгдсэн албан бичиг;

Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 16 цаг 00 минут (Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй).

Ирүүлсэн материалыг нээх хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17 цаг 00 минут.

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-13381, Энхтайваны өргөн чөлөө  
16а, Засгийн газрын 9 дүгээр байр, Б корпус, Хүнс, хөдөө  
аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 5 давхарт,  
502 тоот өрөө, утас 261962